СЕРВИС ЗОНЕ ХХК
Дорноговь аймаг, Сайншанд сум
2-р баг Шизуко гудамж 58-34 тоот
И-мэйл: chintsogt@gmail.com
Утас: 99032760, 99807499

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

2024.10.15 № 57

танай ______________-ны №______________-т

Тодруулга хүсэх тухай

Тус компани нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг Даргын тамгын газраас зарласан ДГАСШСЗДТГ/20240101006/02/01 урилгын дугаартай "Манай орц" төсөл (орцны хаалга, гэрэлтүүлэг, камер) ажил тендерт оролцох хүсэлтэй байна.

Манай компани нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Б тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Уг тусгай зөвшөөрөлийн хүрээнд Монгол улсын хэмжээнд мөрдөж буй хүчин төгөлдөр стандартуудын хүрээнд ажил үйлчилгээ явуулах эрхтэй байдаг. Үүнд:

1. MNS 5843:2008 - Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт. Угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага
2. MNS 1548:1972 – 220кВ, түүнээс бага хүчдэлийн цахилгаан тоног төхөөрөмж тэдгээрийн барилга байгууламжийн аянгаас хамгаалах дүрэм ба бүдүүвч
3. MNS 5471:2005 – Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт
4. MNS 6581:2016 – Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний суурилуулалт. Ерөнхий шаардлага
5. MNS 5278:2012 – Шилэн кабелийг залгах, муфтлэх ерөнхий шаардлага зэрэг стандартуудаар ажлын тоо хэмжээ түйцэтгэх боломжтой байна.

Дээрх тендер боломжтой эсэхийг 2024 оны 10-р сарын 19-ны дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ үү.

Тусгай зөвшөөрлийн гэрээг хавсаргав.

ЗАХИРАЛ Н.ЦЭНДМАА

Д.Сэржмядаг
2024.10.18

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

## ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙН СУУРИЛУУЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ

Дугаар 12100754
/тусгай зөвшөөрлийн дугаар/

1. СЕРВИС ЗОНЕ ХХК
Регистрийн дугаар: 3322181
/зөвшөөрөл эзэмшигчийн нэр, регистрийн дугаар/

2. 101, 34 тоот, Шизуко 1, 2 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, Монгол Улс
Утас: 99807499, 99032760
/зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, утасны дугаар/

3. Цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт,
Гадна холбооны кабель шугамын угсралт
Монгол Улсын нутаг дэвсгэрт
/үйлчилгээний хүртээмж, эрхлэх үйл ажиллагаа, хамрах хүрээ/

4. ХХЗХ-ны 2024 оны 60 дугаар тогтоол
/тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн огноо, дугаар/

5. Эхлэх 2024.03.29 Дуусах 2029.03.29
/тусгай зөвшөөрлийн эхлэх, дуусах огноо/

Тусгай зөвшөөрөл нь гэрээний хамт хүчинтэй

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Б.ЧИНЗОРИГ

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон огноо
2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

БАТЛАВ.
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
/Г.ЧИНЗОРИГ/

БАТЛАВ.
СЕРВИС ЗОНЕ ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
/Н.ЦЭНДМАА/

# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙН СУУРИЛУУЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ 12100754 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЭЭ

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү тусгай зөвшөөрлийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон Иргэний хуулийг тус тус үндэслэн,

Нэг талаас: 9089314 тоот регистрийн дугаартай Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид "Зохицуулах хороо" гэх)
Нөгөө талаас: 3322181 тоот регистрийн дугаартай Сервис зоне ХХК (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар нь Зохицуулах хорооны 2024 оны 60-р тогтоолыг үндэслэн байгуулав.

1.2. Гэрээний хугацаа: 2024 оны 3 сарын 29-ны өдрөөс 2029 оны 3 сарын 29-ны өдрийн хооронд 5 жилийн хугацаатай байна.

1.3.Талуудын албан ёсны мэдээлэл:

| ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО | СЕРВИС ЗОНЕ ХХК |
|---|---|
| Хаяг: Метро бизнес төв, А-блок, 5 давхар, Бага тойруу, 6 дугаар хороо, Сүхбаатарын гудамж-13, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201 | Хаяг: 101, 34 тоот, Шизуко 1, 2-р баг, Сайншанд сум, Дорноговь |
| Утас: 304258 | Утас: 99807499, 99032760 |
| Факс: 327720 | |
| Цахим хуудас: www.crc.gov.mn | Цахим хуудас: |
| Цахим шуудангийн хаяг: info@crc.gov.mn | Цахим шуудангийн хаяг: tseegii_mgl3@gmail.com |

1.4.Тусгай зөвшөөрлийн үйлчлэх нутаг дэвсгэр: Монгол улс,
1.5.Үйлчилгээний хүртээмж, зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагааны төрөл:
- Цамхаг, түүн дээрх холбооны тоног төхөөрөмж угсралт,
- Гадна холбооны кабель шугамын угсралт.

## 2. ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛҮҮД

2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Зөрчлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү гэрээ болон гэрээний Хавсралт 1-т заасан дүрэм, журам, зохицуулалтын баримт бичиг, нөхцөл шаардлага, үндэсний стандарт, норм, норматив баримт бичгийг дагаж мөрдөх үүрэгтэй.
2.2.Зохицуулах хороо нь өөрийн баталсан дүрэм, журам, шийдвэр, зохицуулалтын үйлчилгээний хэлс, нөхцөл, шаардлага, стандарт зэрэг тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамааралтай, эрх зүйн үр дагавар бүхий баримт бичгийг шинээр баталсан, эсхүл нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулга оруулсан бол өөрийн цахим хуудас, цахим шуудан эсхүл албан бичгээр мэдээлнэ.

Харилцаа холбооны ... ХХЗХ

4.7.Радио давтамжийн зурвасыг чөлөөлөх зохицуулалт хийж, тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийг хугацаанаас нь өмнө хүчингүй болгосон, дуусгавар болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийн тухайн жилийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
4.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, энэхүү гэрээнд заасан хугацаанд төлбөрөө бүрэн барагдуулаагүй, төлбөрийн зөрчилтэй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд шилжүүлнэ.

## 5. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

5.1.Хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа 5 (тав)-н хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдох бөгөөд гэнэтийн давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.
5.2.Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, онц байдал зарлах, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгох бөгөөд гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## 6. ХАРИУЦЛАГА

6.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, норм, норматив баримт бичиг, стандарт, нөхцөл шаардлага болон энэхүү гэрээг удаа дараа зөрчсөн буюу ноцтой зөрчсөн, эсхүл хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлнэ.
6.2.Тусгай зөвшөөрлийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, биелүүлсэн бол тусгай зөвшөөрлийг сэргээнэ.
6.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хууль бусаар ашигласан, засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаас нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

## 7. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1.Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
7.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг Зохицуулах хорооноос баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

## 8. БУСАД ЗҮЙЛ

8.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчилсэн байдлаар буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
8.2.Холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт, зохицуулалтын шийдвэр, үйл ажиллагааны улмаас энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.
8.3.Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
8.4.Энэхүү гэрээний 1.3-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн албан ёсны мэдээлэлд заасан хаяг болон цахим шуудангийн хаягаар дамжуулан тусгай зөвшөөрлийн гэрээтэй

2.3.Зөвшөөрөл эзэмшигч нь өрсөлдөөний эсрэг аливаа үйлдэл гаргахгүй, харилцан ялгаварлахгүйгээр ижил тэгш нөхцөлөөр ил тод, нээлттэй, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллана.

2.4.Зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос урьдчилан мэдэгдсэнийг үндэслэн энэхүү тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтийг шалгуулах зорилгоор Зохицуулах хорооны ажилтныг ажлын байранд нэвтрэх, шаардсан баримт бичгийн хуулбарыг авах, тоног төхөөрөмжид хэмжилт шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангана.

2.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний Хавсралт 3-т заасан жишиг маягтын дагуу энэхүү гэрээний хэрэгжилтийг нөхцөл, шаардлага, гэрээний үүрэг бүрээр гарган, жил бүрийн 02 сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ.

2.6.Монгол Улсад онц болон дайны байдал зарласан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд холбооны сүлжээг хууль тогтоомжийн дагуу саадгүй хэрэглүүлнэ.

2.7.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулна.

## 3. МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ, ШАЛГУУЛАХ ЗОХИЦУУЛАЛТ

3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг, байршил, удирдлага, холбоо барих ажилтны мэдээлэл, хувьцаа эзэмшигч үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаарх мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлт орсноос хойш 10 хоногийн дотор Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

3.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооны даргын тушаалаар батлагдсан маягтын дагуу тухайн жилийн статистик тайлан мэдээг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн статистик тайлан, мэдээг тухайн оны 8 дугаар сарын 1-ний дотор тухайн хугацааны санхүүгийн тайлангийн хуулбарын хамт тус тус Зохицуулах хороонд ирүүлнэ.

3.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос тодорхой үндэслэлтэйгээр бичгээр шаардсаны дагуу энэхүү тусгай зөвшөөрөлд хамаарах баримт бичиг эсхүл мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлнэ.

3.4.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү тусгай зөвшөөрлөөр олгогдсон үйлчилгээнд хамаарах, Зохицуулах хорооноос шаардсан аливаа мэдээллийг нууц гэсэн шалтгаанаар ирүүлэхээс татгалзахгүй бөгөөд тухайн байгууллагын нууцад хамаарах мэдээллийг Зохицуулах хороо өөрийн баталсан нууцын журмын дагуу ашиглана.

## 4. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

4.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөр 1.800.000 /нэг сая найман зуун мянга/ төгрөгийг Зохицуулах хорооноос баталсан "Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ"-нд заасан дагуу тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааны туршид жил бүр Голомт банкин дахь Зохицуулах хорооны 1102626829 тоот дансанд төлнө.

4.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь улсын тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 30, 42.4-р зүйл заалтыг үндэслэн тусгай зөвшөөрөл шинээр авах мөн зөвшөөрлийн хугацааг сунгуулах тохиолдолд Голомт банкин дахь Зохицуулах хорооны 1165009467 тоот дансанд төлнө.

4.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулснаас хойш 10 хоногийн дотор төлнө.

4.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг жил бүрийн тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гарсан өдрөөс / 3 сарын 29-ны өдөр/ нэг сарын өмнө төлнө.

4.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч энэхүү гэрээний 4.3, 4.4-т заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12.2-т заасан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн хугацаанд тусгай зөвшөөрөлд заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.6.Зохицуулах хороо нь энэ журмын 4.1-т заасан зөвшөөрлийн төлбөрийн хэмжээнд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдэгдэх ба зөвшөөрөл эзэмшигч нь 30 хоногийн дотор гэрээгээ өөрчлөх хүсэлт ирүүлнэ.

4.7.Радио давтамжийн зурвасыг чөлөөлөх зохицуулалт хийж, тусгай зөвшөөрлийг
хугацаанаас нь өмнө хүчингүй болгохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрлийг хугацаанаас
нь өмнө хүчингүй болгосон, дуусгавар болгосон тохиолдолд тусгай зөвшөөрлийн тухайн
жилийн төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.
4.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль, энэхүү гэрээнд заасан хугацаанд төлбөрөө бүрэн
барагдуулаагүй, төлбөрийн зөрчилтэй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн
мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд шилжүүлнэ.

## 5. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

5.1.Хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг
нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа 5
(тав)-н хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү
нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдох бөгөөд гэнэтийн давагдашгүй хүчин зүйл
үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг
гаргуулж авна.
5.2.Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга
цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх
замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц
халдварт өвчин, онц байдал зарлах, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий
байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн
гэнэтийн огцом ачааллал талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгох бөгөөд
гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар
үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## 6. ХАРИУЦЛАГА

6.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай
хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам,
норм, норматив баримт бичиг, стандарт, нөхцөл шаардлага болон энэхүү гэрээг удаа дараа
зөрчсөн буюу ноцтой зөрчсөн, эсхүл хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг тогтоосон
хугацаанд арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу түдгэлзүүлнэ.
6.2.Тусгай зөвшөөрлийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан
шаардлагыг биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, биелүүлсэн бол тусгай
зөвшөөрлийг сэргээнэ.
6.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хууль бусаар ашигласан,
засварласан, бусдад шилжүүлсэн, барьцаалсан, тусгай зөвшөөрөл шинээр авах болон
сунгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаас нотлогдсон
тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

## 7. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1.Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр
шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв нэгдсэн шийдвэрт эс хүрвэл Монгол улсын хууль
тогтоомжийн дагуу Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
7.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрөлд заасан үйлчилгээтэй холбогдуулан
иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг Зохицуулах
хорооноос баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

## 8. БУСАД ЗҮЙЛ

8.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд
хэсэгчилсэн байдлаар буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
8.2.Холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт,
зохицуулалтын шийдвэр, үйл ажиллагааны улмаас энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж
болно. Нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.
8.3.Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж
баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
8.4.Энэхүү гэрээний 1.3-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн албан ёсны мэдээлэлд
заасан хаяг болон цахим шуудангийн хаягаар дамжуулан тусгай зөвшөөрлийн гэрээтэй

ХУУЛЬЧ

холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд хүргэгдэх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь албан ёсны мэдээлэл солигдох бүрт Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

8.5.Гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хувь бүр хуулийн хувьд ижил хүчин төгөлдөр байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:**

..............................

ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Т.БАТБОЛД

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.УУГАНБАТ

**СЕРВИС ЗОНЕ ХХК ТӨЛӨӨЛЖ:**

ДОРНОГОВЬ АЙМАГ
СЕРВИС ЗОНЕ ХХК

..............................

Зохицуулах хороо болон Сервис зоне ХХК
хооронд байгуулагдсан 2024 оны 12100754
тоот гэрээний Хавсралт 1

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ДАГАЖ МӨРДӨХ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага / Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээнд /
2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн чанар, үндсэн үзүүлэлт, техникийн нөхцөлд тавигдах нөхцөл шаардлага
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ
4. Харилцаа холбооны үйлчилгээний үнэ, тариф тогтоох зөвлөмж, аргачлал
5. Харилцаа холбооны зохицуулах хорооноос шинээр болон шинэчлэн баталсан, нэмэлт, өөрчлөлт оруулсан бусад баримт бичиг

**Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад мөрдөх үндэсний стандартуудын жагсаалт**

| | |
|---|---|
| MNS 6528:2021 | Дата төвийн харилцаа холбооны болон бусад дэд бүтцийн шаардлага |
| MNS 6498:2015 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага |
| MNS 5148:2015 | Радио давтамжтай цахилгаан соронзон орноос хүнд үзүүлэх нөлөө аюулгүйн түвшинд нийцэж буй эсэхийн үнэлгээ |
| MNS 6497:2015 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн радио спектр, цахилгаан соронзон зохицлын техникийн ерөнхий шаардлага |
| MNS 2361:1997 | Дамжуулан нэвтрүүлэх радио зангилааны станц болон утсан холбооны суурин төхөөрөмжийн газардуулга. Эсэргүүцлийн хэмжээ |
| MNS 5594:2020 | Цахилгаан соронзон орон ба цахилгаан соронзон оронгоос хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (0 Гц-ээс 300 ГГц хүртэл) |
| MNS 6499:2015 | Хүний биед ойр хэрэглэдэг утасгүй холбооны төхөөрөмжийн нөлөөллөөр үүсэх онцгой шингээлтийн хэмжээг тодорхойлох арга (30МГц-ээс 6 ГГц-ийн давтамжийн цараанд) |
| MNS 5762:2007 | Цамхагт суурилуулсан антен фидерийн байгууламж. Аюулгүй ажиллагааны шаардлага. |
| MNS 6590:2016 | Радио холбооны антен, фидерийн байгууламжид ажиллах аюулгүй ажиллагааны шаардлага |
| MNS 6586:2016 | Барилгын зураг. Барилга байгууламжийн мэдээлэл, холбоо, дохиоллын ажлын зураг төсөл боловсруулах. Ерөнхий шаардлага |
| MNS 6305:2012 | Холбооны кабель шугамын ажлын зураг төсөл |
| MNS 6580:2020 | Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт. Ерөнхий шаардлага |
| MNS 6668:2017 | Холбооны худаг, сувагчлалын байгууламжийн техникийн үзүүлэлт, суурилуулалтын шаардлага |
| MNS 5596:2020 | Мэдээлэл холбооны сүлжээний байгууламжид ажиллагсдад тавих аюулгүй ажиллагааны шаардлага |
| MNS 5843:2008 | Хамгаалалтын дохиоллын тоног төхөөрөмжийн техникийн үндсэн үзүүлэлт. Угсралт суурилуулалт, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага |
| MNS 1548:1972 | 220 кв, түүнээс бага хүчдэлийн цахилгааны тоног төхөөрөмж тэдгээрийн барилга байгууламжийг аянгаас хамгаалах дүрэм ба бүдүүвч |
| MNS 5471:2005 | Барилгын дотор холбоо, дохиоллын сувагчлал ба кабелийн угсралт |
| MNS 6581:2016 | Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний суурилуулалт. Ерөнхий шаардлага |

| | |
|---|---|
| MNS 6588:2016 | Мэдээлэл холбооны суурин сүлжээний сувагчлалын хоолойд уян нийлэг дэд сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага |
| MNS 6589:2016 | Мэдээлэл холбооны суурин сүлжээнд шилэн кабелийн бичил хоолойн сувагчлал суурилуулах ерөнхий шаардлага |
| MNS 2978:1980 | Холбооны агаарын шугамын модон хөндлөвч |
| MNS 5207:2011 | Шилэн кабелийн суурилуулалт. Техникийн шаардлага |
| MNS 5017:2001 | Телефон сүлжээний сувагчлалд зориулсан хуванцар яндан. Техникийн ерөнхий шаардлага |
| MNS 5276:2013 | Холбооны кабелийн суурилуулалт. Ерөнхий шаардлага |
| MNS 5277:2003 | Кабелийг залгах, муфтлах. Ерөнхий шаардлага |
| MNS 5278:2012 | Шилэн кабелийг залгах, муфтлэх ерөнхий шаардлага |
| MNS 5281:2003 | Кабелийн цахилгааны үзүүлэлт. Ерөнхий шаардлага |
| MNS 6544:2015 | Шилэн кабелийг шалгах аргачлал |
| MNS 6597:2021 | Холбооны кабель шугамыг авто зам, төмөр замыг хөндлөн гаргах болон гүүрний байгууламжаар дамжуулан суурилуулахад тавих ерөнхий шаардлага |
| MNS 6423:2019 | Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага |
| MNS 5884:2020 | Холбооны цамхаг болон антены суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага |
| MNS 6669:2017 | Харилцаа холбооны зай тэжээлийн ба нөөц тэжээлийн төхөөрөмжийн өрөөний ерөнхий шаардлага |
| MNS 5740:2007 | Тоон технологитой мэдээлэл холбооны тоног төхөөрөмжийн цахилгаан тэжээл. Техникийн ерөнхий шаардлага |
| MNS 5536:2005 | Мэдээллийн сүлжээний зангилаа болон сэлгэгчийн техникийн үндсэн шаардлага |
| MNS 6869:2020 | Мэдээлэл, харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага |
| ТБУХ-1, ТБУХ-2, ТБУХ-3 | Холбооны сувагчлалын байгууламжид хэрэглэгдэх төмөр бетон угсармал худгийн нэг маягийн зураг /Барилга бүтээц/ |

Харилцаа холбооны
[illegible]
ХУУЛБАР

Зохицуулах хороо болон Сервис зоне ХХК хооронд байгуулагдсан 2024 оны 12100754 тоот гэрээний Хавсралт 2

# ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

| | Овог нэр | Хариуцах ажил | Албан тушаал | Гар утас | И-мэйл хаяг |
|---|---|---|---|---|---|
| **Харилцаа холбооны зохицуулах хороо** | | | | | |
| 1 | Б.Дэлгэрцэцэг | Тусгай зөвшөөрөл, гэрээтэй холбоотой асуудал | Тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн | 99140090 | delgertsetseg@crc.gov.mn |
| 2 | Д.Гантуяа | Тооцоо нийлэх, данстай холбоотой асуудал | Орлого хариуцсан мэргэжилтэн | 88097400 | gantuya@crc.gov.mn |
| 3 | М.Эрдэнэцэцэг | Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлт | Зохицуулалтын газрын Зохицуулалтын бодлого төлөвлөлтийн хэлтсийн Ахлах мэргэжилтэн | 91071515 | erdenetsetseg@crc.gov.mn |
| **Сервис зоне ХХК** | | | | | |
| | Овог нэр | Хариуцах ажил | Албан тушаал | Гар утас | И-мэйл хаяг |
| | | | | | |
| | | | | | |

ДОРНОГОВЬ АЙМАГ СЕРВИС ЗОНЕ ХХК

Харилцаа холбооны зохицуулах хороо ХУУЛЬ

Зохицуулах хороо болон Сервис зонe ХХК
хооронд байгуулагдсан 2024 оны 12100754
тоот гэрээний Хавсралт 3

## ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИШИГ МАЯГТ

| Д/д | Гэрээний заалт | Хэрэгжилт | Тайлбар |
|---|---|---|---|
| 1. | | | |
| 2. | | | |
| 3. | | | |
| 4. | | | |
| 5. | | | |
| 6. | | | |
| 7. | | | |
| 8. | | | |
| 9. | | | |

ДОРНОГОВЬ АЙМАГ
СЕРВИС ЗОНЕ ХХК

Харилцаа холбооны
зохицуулах хороо
ХУУЛБАР